

## АФРИКТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

*Д.Золбоо\**

Биднийг бага байхад хар арьстай хүн л харахаараа “куба” гэж ойлгодог, дууддаг байсан үе нэгэнтээ хол хоцорчээ. Өнгөт хар арьстан хүнийг бид өнөөдөр өдөр тутам л харж, уулзаж учирч болохоор болжээ. Харин тэдний эх нутагт, дунд нь ороод явах арай өөр сэтгэгдэл төрж, арай өөр талаас нь харах боломжтой болдог байна.

Эрчимтэйгээр даяаршин буй энэхүү цаг үед бид дуртай үедээ хүссэн мэдээллээ хаанаас ч олж үзэх бололцоотой болсон билээ. Тиймээс Африк тив, африкчүүдийн талаар сүүлийн хэдэн жилд телевизийн “Үүргэвчтэй аялал”-ын нэвтрүүлгүүд, Африкын ноён оргилд авирсан монгол уулчид, Төв Африкт энхийг сахиулж буй монгол цэрэг эрс, Олон улсын гоо бүсгүй шалгаруулах тэмцээн гээд олон шугамаар тодорхой хэмжээний мэдээлэл нэмэгдэж байгаа хэдий ч өөрийн ажиллаж буй салбараасаа энэ газар хөл тавьж байгаагийн хувьд үзэж харснаа бусадтайгаа хуваалцах нь судалгааны чиглэлээр ажиллаж буй өөрийн үүрэг гэж үзсэний дагуу энэхүү тэмдэглэлийг хүргэж байна.

Аялалын үндсэн зорилго нь жил бүр South-South буюу өмнөдийн улс орнуудын нийгмийн салбарын судлаачдад зориулан зохион байгуулдаг зуны сургалтад хамрагдах явдал байв. Энэ жилийн сургалтыг Африкийн Нийгмийн шинжлэх ухааны судалгааны хөгжлийн зөвлөлөөс (CODESRIA) эрхлэн Азийн Улс төр ба Олон улс судлалын ассоциац (APISA), Латин Америкийн Нийгмийн шинжлэх ухааны зөвлөл (CLACSO)-тэй хамтран Сенегал улсын нийслэл Дакар хотноо 2009 оны 2 сарын 9-20-ны хооронд зохион байгуулсан юм. Сургалтын сэдэв нь “Ардчилал ба нийгмийн шударга ёс” гэсэн хөгжиж буй улсуудад түгээмэл тулгарч буй асуудал байсан.

Барууны ертөнцөд Африк судлал тэр дундаа нийгмийн шинжлэх ухааны салбар тасралтгүй хөгжсөөр байгаа хэдий ч энэхүү чиглэл манайд хараахан хөгжих бодит шаардлага, хөрс суурь өнөөг хүртэл бүрэлдэн тогтоогүй нь хэн бүхэн илэрхий билээ. Тухайлбал 2008 оны 5 сарын байдлаар манай улс нийтдээ 149 улстай дипломат харилцаатай дотор Африк тивийн 53 улс орноос нийтдээ 35 улстай дипломат харилцаатайгаас анхлан 1960 онд Гвиней, хамгийн сүүлд 1994 онд Өмнөд Африкийн

\* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

БНУ-тай харилцаа тогтоосон байна. Эндээс харж болох нэг зүйл нь Хар тивийн эдгээр улс орны ихэнхтэй нь хүйтэн дайны үед буюу 1988 оноос өмнө харилцаа тогтоосон байх ба энэ үеэс хойш энэ зүгт тавих манай гадаад бодлогын чиглэл хандлага ерөнхийдөө суларсныг илтгэх бизээ.

Хэдий тийм боловч дэлхийн том гүрнүүдийн харж байгаачлан энэхүү харилцааг улс төр, эдийн засгийн харилцан ашигтай байр суурь гэхээсээ илүүгээр даяаршин буй хавтгай дэлхий ертөнц дээр бие биендээ харилцан мэдлэг, туршлагаа хуваалцах ерөнхий хэрэгцээ шаардлага хангалттай бий. Тухайлбал уул уурхайн үсрэнгүй хөгжлийн өмнө тулж ирээд байгаа манай оронд энэ тивийн байгалийн эрдэс баялаг ихтэй улс орны туулж өнгөрүүлсэн алдаж оносон түүх бол бидэнд бэлхнээ сургамж болох бизээ.

Африкийн улс орнуудын нийгмийн шинжлэх судалгаа шинжилгээг зохион байгуулж, ивээн тэтгэн санхүүжүүлж байдаг олон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллага байдгийн нэг нь энэ удаагийн зуны сургалтыг зохион байгуулсан КОДЕСРИА юм. Энэ байгууллага нь анх 1973 онд Африкийн улс орнуудын нийгмийн шинжлэх салбарын эрдэмтэн судлаачид, тэдний судалгааны ажлыг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор байгуулагдсан байна. Өдгөө жил бүр олон арван хурал семинар зохион байгуулж, нийгмийн ухааны салбар бүрийн олон тооны тогтмол сэтгүүл, ном зохиолыг ивээн тэтгэн хэвлэдэг ажээ. Дөрөв дэх удаагийн энэхүү зуны сургалтыг хамтран зохион байгуулсан Ази, Номхон далай болон Латин Америкийн дээрх хоёр байгууллага ч мөн адил бүс нутагтаа ижил төстэй үйл ажиллагаа явуулан хамтран ажилладаг байна. Иймээс энэ чиглэлээр шимтэн ажиллаж буй шинэ үеийн залууст гадаад ертөнцтэй харьцах цонх цөөн биш болохыг сануулах нь зүй бизээ.

Сенегал гэдэг нэр бидний чихэнд хөл бөмбөгийн сайн баг, дэлхийд алдартай авто машины ралли уралдаан гэсэн утгаар шууд ойлгогдохоос цаашгүй байсныг нуух юун. Очих гэж буй улсынхаа талаарх мэдээллийг АНУ-ын Тагнуулын төв газрын “World fact book” номны цахим хуудас, хамгийн том цахим нэвтэрхий толь болох Wikipedia болон дэлхийг тойрон аялж буй монгол залуу Амайгийн веб хуудас зэргээс зарим нэг мэдээллийн тоймыг сонирхож харсан хэдий ч яг амьдрал дээр нь очиж харах нь “зуу сонссоноос нэг үзэх”-ийн дайны өөр ертөнц ажгуу.

Аялалын эхний зогсоол Бээжинд буугаад хотын төв рүү нь явахдаа энэ их гүрний Олимпын их наадамд зориулан хийсэн

бүтээн байгуулалтыг нь алмайран гайхахаас аргагүй байлаа. Хятад хэл гадарлахгүй хүнд ч гэсэн метро, автобусанд суух зэрэгт үнэхээр хүндрэлгүй амар болгож чаджээ. Нутгаас гараад нийтдээ 3 бүтэн өдрийн аялал, 26 цагийн нислэгийн дараа Атлантын далайн зүүн зах, Африк тивийн баруун эрэгт орших Дакар хотод хөл тавьлаа. Замдаа Эфиопын Аддис-абаб, Мали улсын Бамоко хотоор дамжин Африк тивийг зүүн хойноос нь баруун зах хүртэл хөндлөн туулахдаа анзаарсан нэг зүйл нь зах хязгааргүй мэт үргэлжлэх энэ цэлгэр газарт хаана хүн амьдарч байгаа нь тэр бүр мэдэгдэхгүй юм байна даа л гэж бодож явлаа. Манайд бол хаана нь айл байна, хаана нь мал бэлчиж байгаа зэргийг мэдэж болдогтой харьцуулахад их л өөр сэтгэгдэл төрүүлж байснаа тэмдэглэхийг хүсч байна. Түүнчлэн газар тариалан эрхэлдэг улс орнуудад түгээмэл ажиглагддаг нэгэн сонирхолтой гэж тэмдэглэж болох нэгэн зүйл нь нүүдэлчин ухамсар ахуй соёлын хүрээнд ойлгогддог эцэг малын тухай буюу мал хөнгөлөх гэсэн ойлголт ерөөс байхгүй учраас бэлчиж яваа 5 үхэр байхад 3 бух байх, хотын гудамжаар хөлөглөх хогны тээвэртээ бидний мэддэгээр морь биш харин азаргаа л хөлөглөх зэрэг нь этгээд сонин ажээ.

Дакарын онгоцны буудалд төрсөн анхны сэтгэгдэл гэвэл Африк тивд анх ирж байгаа хүмүүст тавигддаг нэг шаардлага болох “Yellow fever” буюу чичрэг, хумхаа өвчний вакцин хийлгэсэн байхыг шаарддаг нь байлаа. Хэрвээ нутагтаа хийлгээгүй тохиолдолд онгоцны буудал дээр байх эрүүл мэндийн хяналтын албанд ойролцоогоор 15 орчим доллараар хийлгэж болдог ажээ. Шинэ зууны тахал гэсэн аймшгийн талаар залхатлаа сонссон бидний хувьд эмнэлгийн цэвэрхэн орчин гэж хэлж болохооргүй газар зүү хүргүүлнэ гэдэг эхэндээ цочирдмоор л санагдаж байлаа. Гэхдээ усыг нь уувал ёсыг нь дагах нь зөв биз дээ. Энэхүү вакцин хийгээд тусгай сертификат бичиж өгөх ба энэ нь ойролцоогоор 10 жилийн хугацаанд дахин хийлгэх шаардлагагүй дархлаатай болсон гэсэн баталгаа болдог. Уг вакциныг хийлгээгүй тохиолдолд Африкаас буцах үед нь дайран өнгөрөх зарим улс заавал сертификат үзэж байж оруулдаг журамтай байдаг. Тухайлбал миний бие Бангкок хотод буугаад хил нэвтрэх үед хилийн шалганы байцаагч нь Эрүүл ахуйн хяналтын албаараа дамжуулан уг сертификатыг шалгуулж байж эх орондоо оруулж байлаа. Харин манайд бол энэ талаар сонирхож байгаа хүн хил гаалийн албанд байгаагүйн дээр дархлаажуулалтын асуудал хариуцдаг ХӨСҮТ-ийн сайн дурын дархлаажуулалтын хэсэгт энэ жил ЭМЯ-ны тендер зарлагдан

вакцин нь ирж амжаагүй байсан зэргийг бас бодууштай л санагдсан.

Түүнээс гадна бүтэн жилийн турш шумуултай байдаг африк мэтийн газар очих хүмүүсийн анхаарах бас зүйл нь маляр өвчний эсрэг эм бэлдмэл бэлдэх бөгөөд энэ төрлийн эм нь өдөр бүр эсвэл долоо хоногт нэг уудаг гээд үйлчлэх чадлаасаа шалтгаалан олон төрөл байдаг ажээ.

Сенегалын талаар албан тоо баримтаас:

Африк тив нь дэлхийн хоёр дахь том тив бөгөөд нийтдээ 53 улсад ойролцоогоор нэг тэрбум гаруй хүн ам оршин суудаг. Харин Сенегалын хувьд манайхаас 10 дахин бага буюу 197 мянган хавтгай дөрвөлжин газар нутагт 12 сая хүн амтайгаас нийслэл Дакардаа 2,4 сая нь оршин суудаг байна. Мөнгөний нэгж нь франк фса (Fcf), 530 орчим нь нэг доллартай тэнцэж байгаа энэ ханшаа нэлээд олон жил хадгалж ирсэн байна. Хүн амын 94 хувь нь исламын шашинтай, албан ёсны хэл нь франц. Бүх ард түмнээс сонгогддог ерөнхийлөгч болон 150 суудалтай парламент бүхий Бүгд найрамдах засаглалтай улс ажээ. Харин нэг хүнд ноогдох ДНБ нь өнгөрсөн жил 1800\$ гэж бүртгэгдсэн байна. Олон улсын байгууллагын судалгаагаар Авилгалын ерөнхий индексээр дэлхийн 146 улсаас манай дараахан 86-д жагсдаг ажээ. Эдгээр ерөнхий төвшнөөс нь харвал манайхтай амьдралын төвшин бараг ижил төвшинд юм уу даа гэмээр.

Харин хувь хүний хувьд анзаарсанаа тэмдэглэхэд, энэ тивийн улсууд аль улсын колончиллолд байснаасаа хамааран ялгавартай байдаг нь анзаарагдах юм. Тухайлбал Сенегалын хувьд францын колони байсныхаа хувьд хүмүүс нь ерөнхийдөө их найрсаг, илэн далангүй, тусархуу хүмүүс болох нь анзаарагдсан бөгөөд бусад Африкийн улсуудаас ирсэн хүмүүс ч гэсэн энэ талаар санал нэгтэй байсан. Хар арьстан хүмүүсийн ерөнхий хэлбэр төрхийг хадгалсан өндөр биетэй шөрмөслөг залуус, уран гуалиг биетэй охид хүүхнүүд нь энэ орны бахархал. Тэндхийн өвлийн улирал нь таарсан тул цаг агаарын хувьд нэг их халуунгүй 20-25 градусын дулаантай байсан ба оройн цагаар гадуур хүрэм өмсөхөөр байсан зэргийг зам зуур дайрсан Тайландтай харьцуулбал харин ч сэрүүхэн талдаа.

Хэдийгээр албан ёсоор 90 орчим хувь нь исламын шүтлэгтэй боловч зарим нэг хатуу чанга дүрэм журамтай улс орны хүмүүстэй харьцуулахад Аллахдаа мөргөж орж ирээд архи, пивоо ууж байгаа зэрэг нь их л сонирхолтой, чөлөөтэй ч юм уу гэмээр байлаа.

Бидний адил шар арьст Ази дүр төрхтэй хүн харин Африкийн улс орнуудад нэг их сонин содон санагдахаа больсон нь энэ тивийн улс орнуудад Азийн улс орны тэр дундаа Хятадын хөрөнгө оруулалт, худалдаа бизнес ихээхэн нэвтэрсэнтэй нь холбоотой биз. Зэргэлдээ байрлах жирийн нэгэн жижигхэн хотод нь автобус дүүрэн үйлдвэрийн хятад ажилчид зөөж яваатай дайралдахад аргагүй л хөрөнгө оруулалтын цар хүрээг нь илтгэнэ. Дэлхий дахины анхаарлыг татаад байгаа далайн дээрэмчдийг номхотгохоор хятадууд тэнгисийн тусгай хүчнээсээ илгээж байгааг нь жишиж бодвол үнэхээр ч аргагүй. Биднийг Дакарт байх үед БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн Африкийн улс орнуудаар хийх албан ёсны айлчлал таарснаас нэгэн хэсэг Азиар амьсгалж байв. Мөн түүнчлэн Бээжин, Бангкокоос Африкийн Аддис-абаб зэрэг хотын зүгт нисч байгаа нислэгээр олон арван “гахай” зөөж байгаа эмэгтэй голдуу хүмүүс нь 90-ээд оны эхэнд манай наймаачин залуус Орос, Хятадаас бараа зөөдөг байсан дүр төрхийг санагдуулах авай.

Томилолтын богинохон хугацааныхаа ихэнхийг Дакар хотод өнгөрөөсний хувьд хотын амьдралтай нь бага зэрэг танилцлаа. Гэрлэн дохио бараг байхгүй шахам энэ хотод францын голдуу машин хөлхөх бөгөөд хөдөө хээр газар ганц нэг Hyundai Excel-тэй дайралдахад бараг л таньдаг хүнтэй дайралдсан мэт баярлан хөөрснөө бодохоор инээд хүрмээр ч юм шиг. Манай үндэсний оператор Мобикомын мессеж роуминг үйлчилгээ миний очсон Африкийн орнуудад хамрагддаггүй бөгөөд түүнчлэн тэдний өөрсдийнх нь үүрэн холбооны утасны картаар гадаад улс руу холбогдож болоод байгаа хэрнээ Монгол руугаа залгаж боломжгүй байсан нь үнэхээр хачирхалтай санагдсаныг нуух юун. Харин интернэтийн сүлжээ байгаа л бол сонин, телевиз, утсан харилцаа гэх зэргээр эх нутагтайгаа хямдхан заррдаар байнгын холбоотой байх боломж бүрдсэн нь бидний амьдран буй цаг үеийн нэгэн бахархал.

Сенегал бол Африктаа амьдралын өртөг өндөртэй, хамгийн үнэтэй хотын тоонд ордог гэх ба энэ нь нэг таваг хоол 5-7\$ байдгаас нь харагдах юм. Харин энэ улсын хамгийн бахархалтай зүйлийн нэг нь өндөр хөгжсөн жуулчлалын бизнесээ дагаад бүс нутагтаа хамгийн амар тайван орон гэдэг нь мэдрэгдэж байлаа. Бусдын нэгэн адил очсон газраа Монголтойгоо харьцуулан бодож явахад нэлээд зүйл анзаарагдаж байлаа. Хамгийн түрүүнд энхэл донхолтой зам, замын бөглөрөл түгжрэлээс гадна нийтийн тээвэрт

үйлчилж байгаа микро автобуснууд нь энэ улсын нэг ёсны нүүр царай болсон гэдэг нь анзаарагдаж байлаа. Манайхантай адил орилолдон хүнээ булаацалдах кондукторууд, хөдөлж л байвал хамаагүй гэсэн мэт сарампай болсон хуучин боловч галзуу мэт давхилдах таксинууд гээд л адилтгах зүйл олон байсан.

Тиймдээ цөөхөн хүн амтай ч, эрдэс баялгаар хэний ч доор орохооргүй улсын нийслэлийг баруун Африкийн хэмжээнд байлгаж чадаж байгаад нь нийслэл хотынхоо удирдлагад баярламаар ч юм шиг. Хүүхэд залуус нь хаа дайралдсан газраа хөл бөмбөг өшиглөн тоглох нь үндэсний спорт нь юм уу гэмээр. Харин Laamb гэж нэрлэдэг Сенегалын үндэсний бөх нь манай зодог шуудаг санагдуулам тусгай өмсгөл өмсөн задгай элсэн дээр өрж зогсоод эхэлж байгаа нь бокс, зодооны төрлийн спорттой төстэй боловч барилцаж авсан дараа унагааж байгаа мэх нь манай үндэсний бөхтэй төстэй санагдсан билээ. Хувь хүмүүсийн өдөр тутмын хийдэг нэг үйлдэл нь амандаа модны мөчир зуугаад шүдээ зүлгүүрдэн цэвэрлэж бөх бөт болгодог гэх бөгөөд үүнийгээ уран зурагтаа хүртэл дүрсэлсэн байхыг нь анзаарвал ихээхэн ач холбогдол өгдөг болох нь мэдэгдэнэ.

Далайн эргийн дагуу байрлах олон тооны амралтын газар, Африкийн зэрлэг онгон байгалиас гадна гадны жуулчдын сонирхлыг татдаг газраас өөрийн очиж үзсэн зарим нэгийг танилцуулья. Сенегалын төдийгүй баруун Африкийн улс орнуудын түүхэнд тод ул мөрөө үлдээсэн газрын нэг нь далайн эргээс 5 орчим км алслагдан орших цагаан арьстнуудын энэ тивд ирэхдээ анх суурьшиж байсан, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн Горея хэмээх жижигхэн арал ажээ. XVII зуунаас эхэлсэн олон жил үргэлжилсэн боолын наймааны дамжин өнгөрөх гол гарц болж байсан энэ арал дээр өдгөө музей болсон олон шоронгийн хананаас тухайн үеийн сая сая боолуудын ачигдахаасаа өмнө мэдэрч, эдэлж байсан зовлон гуниг, айдас хүйдсийг мэдэрч болохоор тохижуулжээ. Дараагийн газар нь Төв Африктаа хамгийн чанарлаг байгалийн давс олзворлодог гэх Ягаан нуур байлаа. Нуурын ёроолоор байдаг байгалийн чулууны оронд зөвхөн хясааны яснаас тогтсон энэ нуур нь өөртөө агуулагдах байгалийн болоод химийн найрлагын онцлогоосоо шалтгаалаад өдрийн наранд ягаан өнгөтэй болж харагддаг байна.

Хичээлийн хажуугаар зав гарган Сенегалын Үндэсний архивтай холбоо барин зочилж үзэх хүсэлтээ илэрхийлэхэд захирал ноён Бабако Нжай дуртайяа хүлээн авч өөрийн

байгууллагын талаар товч танилцуулсан. Засгийн газрын яамдын нэгдсэн байрны нэгдүгээр давхарт байрлах, 1816 оноос хойшхи улсынхаа болон баруун Африкийн түүхэнд холбогдох арвин сан хөмрөгтэй энэ архивт нийтдээ 35 орчим хүн ажилладаг ажээ. Эндхийн нэг онцлог нь номын сан нь архивтайгаа цугтаа байдаг бөгөөд ирээдүйд баригдах шинэ байрных нь төсөлд тусдаа боловч бүхэл цогцолбор болгон нэг газар барихаар төлөвлөсөн байх ажээ. Засаг захиргааны нэгж мужуудад нь орон нутгийн архив байх ба боловсон хүчний хангалтын асуудал хүндрэлтэй байдаг ажээ. Энэ нь төсвийн байгууллагын цалин хангамж бага учраас залуус тэр бүр орох сонирхолгүй байдагтай холбон тайлбарлаж байв.

Сэтгүүлийн дараагийн дугаартаа дэлхийн улс орнуудын Африк судлалын ерөнхий тойм болон онцлог, энэ тивийн улс орнуудын гадаад харилцааны онцлог мөн түүнчлэн Хятадаас Африкт явуулж буй улс төр эдийн засгийн бодлогын талаарх бичил өгүүлэл нийтлүүлнэ.

Тэмдэглэлийнхээ төгсгөлд энэхүү сайхан газар нутаг, Сенегал оронтой халт ч болов танилцах гайхалтай боломжийг олгосон CODESRIA болон APISA-ийн удирдах зөвлөл хамт олон, ОУСХ-ийн хамт олон тэр дундаа эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Шүрхүү гуай нартаа талархаснаа илэрхийлэхийг хүсч байна.

*Сайн уйлс бүхэн дэлгэрэх болтугай.*

### ЭХ СУРВАЛЖ

- [http://www.mfat.gov.mn/index.php?option=com\\_content&task=view&id=47&Itemid=85](http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=47&Itemid=85)
- (<http://www.codesria.org>)
- (<http://www.apisanet.com/>)
- [http://www.transparency.org/policy\\_research/surveys\\_indices/cpi/2004](http://www.transparency.org/policy_research/surveys_indices/cpi/2004)
- (<http://www.clacso.org.ar>)
- (<https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/geos/sg.html>)
- (<http://en.wikipedia.org/wiki/Senegal>)
- (<http://www.amai.mn/archives/category/diary/senegal-diary>)
- (<http://en.wikipedia.org/wiki/Gor%C3%A9e>)
- ([http://www.galenfrysinger.com/senegal\\_pink\\_lake.htm](http://www.galenfrysinger.com/senegal_pink_lake.htm))